**3. Монгол Улсын гаалийн байгууллагын гадаад хамтын ажиллагаа:**









Танд лавлах зүйл байна уу!



**1800-1281**

Гааль сонсож байна




## ГААЛИЙН ЛАВЛАХ УТАС

Гаалийн байгууллагын үйл ажиллагаатай холбоотой асуудлаар үйлчлүүлэгч иргэд, аж ахуйн нэгж, байгууллагын санал, хүсэлт, гомдол, мэдээллийг хүлээн авах, гаалийн хууль тогтоомж, заавар, журам, гаалийн үйлчилгээний талаар мэдээ, мэдээллээр хангах, сан бүрдүүлэх зорилгоор **“Гаалийн лавлах-1281”** нээлттэй утас ажиллуулж байна.

Гаалийн байгууллагын үйл ажиллагааны талаархи иргэд, байгууллагын асуултуудыг нэгтгэн, дүн шинжилгээ хийж, дүгнэлт гарган мэдээлэл, гомдол саналын мөрөөр шаардлагатай арга хэмжээ авах, хэвлэл мэдээллийн байгууллагуудтай хамтран ажиллаж, мэдээлэл, зөвлөлгөө өгөх, сурталчилгаа хийх болон гаалийн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг авч хэрэгжүүлж байна.

**Хаяг:**
Сүхбаатар дүүрэг, ”Их тойруу-81/1”,
Улаанбаатар-14193, Монгол Улс
Утас: (976-11) - 351986; 70130070
Факс: (976-11) - 350048
E-mail: info@customs.mn
Интернет: http://www.customs.gov.mn



МОНГОЛ УЛСЫН
ГААЛИЙН ЕРӨНХИЙ ГАЗАР

# ИТГЭМЖЛЭГДСЭН АЖ АХУЙН НЭГЖИЙН ХӨТӨЛБӨР, ОЛОН УЛСЫН ХАМТЫН АЖИЛЛАГАА

УЛААНБААТАР ХОТ
2019 ОН

## 1. ХЯТАД УЛСЫН ТУРШЛАГА:

**Хөтөлбөрийн нэр:** Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн хөтөлбөр (ИААН);
**Хэрэгжүүлсэн он:** 2014 он;
**Чиглэл:** экспорт импорт;
**ИААН-ийн төрөл:** Импортлогч, Экспортлогч, Гаалийн зуучлагч;
**ИААН-ийн тоо:** 3050 аж ахуйн нэгж;
**ДГБ-ын ангилал:** ИААН-ийн хөтөлбөр.

**Ерөнхий тавигдах шаардлага:**

-Аж ахуйн нэгжийн хууль сахилтын түвшин сайн;

-Үйл ажиллагааны санхүүгийн чадавхитай байх;

-Аж ахуйн нэгжийн дотоод хяналтын систем сайн байх

-Гадаад худалдааны аюулгүй байдлын стандартыг хангасан байх

- Нэмэлт шалгуур: гаалийн тусгай хяналтын бүсэд байрлах, 3Г-аас тогтоосон тэргүүлэх чиглэлийн салбарын үйл ажиллагаа эрхэлдэг, Гаалийн зуучлалын холбоо болон бусад холбооноос гаалийн шилдэг аж ахуйн өргөмжлөл авсан байх.

**Гаалийн байгууллагаас үзүүлэх хөнгөлөлт:**

-Гаалийн байгууллагын итгэлийг авах;

-Гаалийн хэргийн талаар зөвлөгөө өгөх, хамтарч ажиллах тусгай албан тушаалтан томилох;

-Бараанд хийх шалгалтыг хамгийн боломжит бага түвшинд хийх;

-Бүртгүүлсэн газраа мэдүүлэх;

-Тухайн аж ахуйн нэгжийн байр агуулахад гаалийн бүрдүүлэлтийг хийх;

-ААН-ийн хүссэн газар тусгай баг илгээж гаалийн хяналт бүрдүүлэлтийг хийх;

-Амралтын болон ажлын бус цагаар гаалийн бүрдүүлэлтийг түргэвчлэн хийх;

-Гаалийн хяналтын зорилгоор мэдүүлэг, засвар буцаалт, шалгалтын үр дүн зэрэг худалдааны бичиг баримтын түвшинд шалгалт хийх;

-Гаалийн байгууллагад мэдүүлэх түвшинд гаалийн бүрдүүлэлтийг хийх.

*http://credit.customs.gov.cn*

## 2. СОЛОНГОС УЛСЫН ТУРШЛАГА:

**Хөтөлбөрийн нэр:** Итгэмжлэгдсэн аж ахуйн нэгжийн хөтөлбөр (ИААН);
**Хэрэгжүүлсэн он:** 2009 оны 4 дүгээр сар;
**ИААН-ийн тоо:** 914 ААН;
**Экспортлогч -** 313 ААН;
**Импортлогч -** 158 ААН;
**Гаалийн зуучлагч -** 124 ААН;
**Тээвэр зууч -** 201 ААН;
**Агуулах эрхлэгч -** 48 ААН;
**Тээвэрлэгч -** 49 ААН.

**Онцлог:** ААН-ийг хууль сахилтын түвшингээр үнэлж, ангилах - А, АА, ААА, үүнд:

**А -** 80 ба түүнээс дээш оноо авах;

**АА -** 90 ба түүнээс дээш оноо авах;

**ААА -** 95 ба түүнээс дээш оноо авах.

**Гаалийн байгууллагаас үзүүлэх хөнгөлөлт:**

- Гаалийн аудитаас чөлөөлөх (гадаад валютаар хийсэн хэлцэлд хийх шалгалт);

- Цахимаар бүрдүүлэлт хийх боломж олгох;

- Гаалийн хяналт шалгалтаас тодорхой түвшинд чөлөөлөх, хэрэв сонгон шалгагдах бол нэн тэргүүнд дараалал харгалзахгүй хяналт шалгалтыг хийх;

- Татвар төлөлтийг сард нэг удаа хийдэг болгох, шийтгэл торгуулийн хураамжийг бууруулах;

- ОУНБ-ын хөнгөлөлтэй гарцаар нэвтрэх боломж олгох гэх мэт.

**ИААН-ийн хөтөлбөр харилцан хүлээн зөвшөөрөх хэлэлцээр байгуулсан байдал:**

Канад, Сингапур, АНУ, Япон, Шинэ Зеланд, Хятад, Гонгконг, Мексик, Турк, Израйль, БНДоминикан Улс, Энэтхэг, Тайланд, Малайз, Перу.





1 AEO = Ашиг, орлого, бизнесийн хөгжил дэвшил

2 AEO = Нэр хүндийн баталгаа

3 AEO = Олон улсад өрсөлдөх чадвар

Урамшуулал

Хамтарсан:

Хариуцлагын систем

Итгэл дааж, хууль сахисан байдал = Худалдаа хөнгөвчлөгдөнө.

Итгэл алдаж, хууль зөрчсөн байдал = Хариуцлагын систем үйлчилнэ.